

“СилкНэт” ХК-ийн 2019 оны үйл ажилагааны тайлан

“Силк Нэт” ХК нь 2019 онд Монголын мэдээлэлийн технологи, Финтекийн салбарт ажилласан жил боллоо.

2019 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзвэл, дараах байдалтай байна:

1. Компанийн санхүү

- Үндэсний аудитын Мэжик Аудит Консалтинг компаниар 2019 оны санхүүгийн аудитын тайланг хийлгэсэн.
- Компанийн үйл ажиллагааг амжилттай үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай удирлагын баг, зөвлөх баг болон хөгжүүлэгчдийн багийг бүрдүүлсэн
- Цалин урамшуулалын системийг тодорхой болгосон
- Нэмэлт хөрөнгө оруулалт татах ажил үргэлжилж байна

2. Програм хангамж хөгжүүлэлт

- Зөвлөх үйлчилгээний платформыг хөрөнгө оруулагчидтай тохиролцсоны дагуу хөгжүүлж эхэлсэн
- Бусад компанийн захиалгын дагуу вэбэд сууринсан програм хангамж, шийдэл хөгжүүлэх, нэвтрүүлэх ажил бэлтгэлээ шатаа дуусгаад байна.

3. Мэргэжлийн Зөвлөх Үйлчилгээ

- Бизнесийн удирдлага, Төслийн удирдлага, Мэдээлэлийн Технологи болон Бизнес стратегитэй холбоотой мэргэжлийн зөвлөх үйлчилгээний багцтай болсон
- Бизнесийн автоматжуулалт, өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр зөвлөгөө өгч эхэлсэн

4. Хөрөнгө оруулалт

Мэдээлэлийн технологийн тодорхой хөрөнгө оруулалтын төслийн танилцуулга хөрөнгө оруулагчдад танилцуулсан. Цаашид нэмэлт хөрөнгө оруулалт татах чиглэлээр үндэсний брокер дилэрийн компани Евразия Капитал Холдинг УЦК-тай хамтран ажиллаж байна.

Криптовалютын судалгаа, олборлолтыг турших үйл ажиллагаанд төслийн санхүүжилтийн бага хүйтэй зээлийг хөрөнгө оруулалтын компаниас босгосон.

5. Хамтын ажиллагаа, түншлэл

Компанийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа мэргэжлийн зөвлөх үйл ажиллагааны хүрээнд эхний ээлжинд үндэсний компаниудтай хамтын ажиллагаа түншлэлийн гэрээ байгуулсан. Эдгээр компанийд татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлдэг компани, уул уурхайн ханган нийлүүлэлтийн компани болон мэдээлэлийн технологийн зөвлөгөө үзүүлэгч зэрэг төрөл бүрийн салбарын үндэсний компаниуд багтаж байна.

Үндэсний финтек стартап компанийг зөвлөн ажиллаж байна. Энэхүү финтек стартап зах зээлийн гарсаа амжилттай болсон тохиолдолд гадны зах зээл рүү гаргах үйл ажиллагааг Силк Нэт ХК хариуцан ажиллахаар хамтарч байна.

6. Үйлчилгээ

Мэдээлэлийн Технологийн Зөвлөх үйлчилгээний хүрээнд одоогийн байдлаар Америкийн Монгол Судлалын Төв болон Пипл ин Нийд зэрэг олон улсын байгууллагуудад Ай Ти шийдлийн зөвлөгөө өгөх, оффис ай ти үйлчилгээг үзүүлж байна.

Оффис ай ти үйлчилгээг сонирхсон гадаадын суурин төлөөлөгчийн газруудад зориулсан онлайн танилцуулга бэлтгэж байна. Үйлчилгээний багцыг дараахь байдлаар тодорхойлсон:

Дуудлагаар үйлчилээ үзүүлэх	Үндсэн багц	Премиум багц	Бүтэн үйлчилгээний багц
-Компьютерын алдаа олж засварлах	-Компьютерын алдаа олж засварлах	-Компьютерын алдаа олж засварлах - Сүлжэний алдаа олж засварлах	-Компьютерын алдаа олж засварлах - Сүлжэний алдаа олж засварлах
- Сүлжэний алдаа олж засварлах	- Сүлжэний алдаа олж засварлах	- Програм суулгах янзлах	- Програм суулгах янзлах
- Програм суулгах янзлах	- Програм суулгах	- Принтерын алдаа олж засварлах	- Принтерын алдаа олж засварлах
- Принтерын алдаа			

олж засварлах - Зөвлөгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах	янзлах - Принтерын алдаа олж засварлах - Зөвлөгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах	- Зөвлөгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах - Дотоодын cloud сервер суулгах - Цахим хуудасын аюулгүй бадлыг улираалаар шалгах - Хүсэлтээр цахим хуудасыг шинэчлэх	- Зөвлөгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах - Дотоодын cloud сервер суулгах - Цахим хуудасын аюулгүй бадлыг улираалаар шалгах - Хүсэлтээр цахим хуудасыг шинэчлэх - Цахим хуудсын мэдээллийн менежмент - Байгууллагын мэдээлэл технологийн стратегийн зөвлөгөө
--	--	---	--

Мөн гадны болон дотоодын компаниудад вэбэд суурилсан програм хангамж хөгжүүлэх болон мэдээлэлийн технологийн шийдлийн зөвлөгөөг өгч байна.

1. Судалгаа шинжилгээ, шинэ төсөл

Финтек технологийн хүрээнд блокчэйн технологи болон криптовалютыг судалж, Монголын банк санхүүгийн салбар дах зээлийн үйл ажиллагаа, борлуулалтын сүлжээ болон улсын системүүдийн уялдаа холбоо зэргийг судалж байна.